



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Баян-Уул сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: ГАА-2022/01/-НА-СТА-ТТЗ

Цахим хуудас: <a href="http://www.audit.mn">www.audit.mn</a> Алтай хот 2022 он	Дарга, Тэргүүлэх аудитор:	Х.Түвшинбаяр
	Утас: 70483413 Цахим хаяг:	tuvshinbayarkh@audit.gov.mn
	Аудитын менежер:	Д.Эрдэнэчимэг
	Утас: 70484055 Цахим хаяг:	erdenechimegd@audit.gov.mn
	Ахлах аудитор:	Ж.Бүжинханд
	Утас: 99177546 Цахим хаяг:	Bujinkhandj@audit.gov.mn
	Аудитор:	Г.Энхдэлгэр
	Утас: 99002291 Цахим хаяг:	Enkhdelgerg@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## Агуулга

1. Аудитын гэрчилгээ.....	3
2. Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлан .....	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан /мянган төгрөг/ .....	5
2.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан /мянган төгрөг/ .....	6
2.3 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан /мянган төгрөг/ .....	7
2.4 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан /мянган төгрөг/ .....	8
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан /мянган төгрөг/.....	9
2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан /мянган төгрөг/.....	10
3. Аудитын тайлан .....	10
3.1. Ерөнхий зүйл .....	10
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт .....	11
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал .....	12
3.4 Материаллаг байдал.....	12
3.5 Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн үзүүлэлт .....	12
3.5.1 Орлогын данс .....	13
3.5.2 Зардлын данс .....	13
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	14
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг.....	15
3.8 Аудитын гол асуудал.....	15
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт.....	15
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	15
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	16
4. Аудитын илрүүлэлт.....	16
5.Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл.....	17
Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	17

### Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагуудын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
ТТЗ	Төсвийн төвлөрүүлэн захирагч
ТШЗ	Төсвийн шууд захирагч
ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал
ЗДТГ	Засаг даргын тамгын газар
ЭМТ	Эрүүл мэндийн төв
ЕБС	Ерөнхий боловсролын сургууль
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан
СХС	Сум хөгжүүлсэн сан



БАЯН-УУЛ СУМЫН ЗАСАГ  
ДАРГА Б.БАТ-ЭРДЭНЭ ТАНАА

**ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

9018301, Говь-Алтай аймаг,  
Есөнбулаг сум, 7-р баг, Жинст 0  
Утас: 70-48-34-13. Факс: (976) 70-48-34-13,  
E-mail: govialtai@audit.gov.mn

2022.03.25 № 197

танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

**Зөрчилгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-д заасны дагуу Баян-Уул сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Баян-Уул сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэх болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  Х.ТҮВШИНБАЯР

07020506

## 2. Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлан

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан /мянган төгрөг/

Код:	Тайлангийн үзүүлэлт	2020оны 12-р сарын 31	2021 оны 12-р сарын 31
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	878,194.8	1,076,479.0
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	246,940.2	272,580.4
32	БОГИНО ХУГАЦААТ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ	-	-
33	АВЛАГА	126,951.8	287,953.4
34	УРЬДЧИЛГАА	-	-
35	БАРАА МАТЕРИАЛ	406,723.4	480,329.1
36	НӨӨЦИЙН БАРАА	35,616.2	35,616.2
360	БУСАД ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГӨ	61,963.3	-
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	5,645,091.8	6,484,757.4
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	5,645,091.8	6,484,757.4
39100	Газар	-	-
39200	Биет хөрөнгө	5,563,352.5	6,399,877.7
39300	Биет бус хөрөнгө	81,739.3	84,879.7
39400	Бусад хөрөнгө /ТӨҮГ/	-	-
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	6,523,286.6	7,561,236.4
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	8,144.1	8,642.2
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	8,144.1	8,642.2
41300	Өглөг	8,144.1	8,642.2
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	6,515,142.5	7,552,594.3
51	Засгийн газрын хувь оролцоо	6,515,142.5	7,552,594.3
51100	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/	2,966,153.6	3,849,806.0
51200	Хуримтлагдсан үр дүн	2,593,099.2	2,398,987.2
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	955,889.7	1,303,801.1
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	6,523,286.6	7,561,236.4

2.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан /мянган төгрөг/

Код:	Тайлангийн үзүүлэлт	2020 оны 12-р сарын 31	2021 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	3,041,766.9	3,566,746.2
11	ТАТВАРЫН ОРЛОГО	88,312.0	188,614.8
110	Орлогын албан татвар	84,732.8	75,340.4
1100	Хувь хүний орлогын албан татвар	84,732.8	75,340.4
113	Хөрөнгийн албан татвар	998.0	794.0
118	Бусад татвар, төлбөр, хураамж	2,581.2	112,480.4
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	291,166.8	465,660.4
120	Нийтлэг татварын бус орлого	291,166.8	465,660.4
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	2,662,288.2	2,912,470.9
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	2,942,456.1	3,461,949.3
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,942,456.1	3,461,949.3
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,170,439.5	3,353,466.5
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,437,195.5	1,910,292.6
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	180,210.1	250,898.3
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	109,956.0	112,679.3
2104	Хангамж, бараа материалын зардал	46,502.0	127,320.2
2105	Нормативт зардал	45,020.4	391,681.2
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	210.5	24,877.7
2107	Томилолт, зочны зардал	5,773.0	7,046.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр,	12,733.0	6,010.8
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	332,838.9	522,660.5
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	772,016.6	108,482.7
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	-	-
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	99,310.8	104,796.9
IV	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН	-	-
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	73,264.5	163,210.1
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	26,046.3	(58,413.2)

2.3 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан /мянган төгрөг/

Код:	Тайлангийн үзүүлэлт	2020 оны 12-р сарын 31	2021 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	2,813,725.9	3,008,888.6
11	ТАТВАРЫН ОРЛОГО	88,312.0	188,614.8
110	Орлогын албан татвар	84,732.8	75,340.4
1100	Хувь хүний орлогын албан татвар	84,732.8	75,340.4
113	Хөрөнгийн албан татвар	998.0	794.0
118	Бусад татвар, төлбөр, хураамж	2,581.2	112,480.4
1180	Бусад нийтлэг төлбөр, хураамж	1,577.0	1,949.5
1181	Газрын төлбөр	1,004.1	1,321.2
1182	Байгалийн нөөц ашигласны төлбөр	-	109,209.6
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	54,125.8	54,247.9
120	Нийтлэг татварын бус орлого	54,125.8	54,247.9
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	2,671,288.2	2,766,025.9
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	2,629,601.4	2,754,303.8
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,629,601.4	2,754,303.8
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,848,584.8	2,645,226.0
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,436,588.2	1,909,167.0
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	180,817.4	250,471.1
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	107,113.1	115,506.6
2104	Хангамж, бараа материалын зардал	45,446.1	70,204.0
2105	Нормативт зардал	35,992.0	223,254.9
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	5,518.5	25,247.4
2107	Томилолт, зочны зардал	5,773.0	7,046.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр,	13,022.5	8,043.4
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	18,314.0	36,285.5
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	781,016.6	109,077.7
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	184,124.5	254,584.8
IV	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН	-	-
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	47,564.1	159,651.2
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	47,564.1	159,651.2
2200	Дотоод эх үүсвэрээр	47,564.1	159,651.2
2260	Гадаад эх үүсвэрээр	-	-
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	(47,564.1)	(159,651.2)
VII	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН	(27,800.0)	(69,293.4)
14	Бусад эх үүсвэр	-	-
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР	27,800.0	69,293.4
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	108,760.4	25,640.2
101	Мөнгө, түүнтэй адилгах хөрөнгийн эхний үлдэгдэл	138,179.8	246,940.2
20	Мөнгө, түүнтэй адилгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	246,940.2	272,580.4

**2.4 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан /мянган төгрөг/**

Код:	Тайлангийн үзүүлэлт	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн	Нийт цэвэр хөрөнгө/өмч
1	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	6,489,096.2	6,489,096.2
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	60,715.2	60,715.2
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	6,549,811.4	6,549,811.4
4	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	(60,715.2)	(60,715.2)
5	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	-	-
6	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-
7	Өмчид гарсан өөрчилөлт	-	-
8	Зарласан ногдол ашиг	-	-
9	Тайлант үеийн үр дүн	26,046.3	26,046.3
10	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	6,515,142.5	6,515,142.5
11	2021 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	6,515,142.5	6,515,142.5
12	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	1,134,998.5	1,134,998.5
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	7,650,141.0	7,650,141.0
14	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	(42,766.2)	(42,766.2)
15	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	3,632.6	3,632.6
16	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-
17	Өмчид гарсан өөрчилөлт	-	-
18	Зарласан ногдол ашиг	-	-
19	Тайлант үеийн үр дүн	(58,413.2)	(58,413.2)
20	2021 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	7,552,594.3	7,552,594.3

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан /мянган төгрөг/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Төсвийн гүйцэтгэлийн тайлан
<b>II</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>2,887,554.2</b>	<b>2,703,790.3</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>2,625,951.7</b>	<b>2,526,139.7</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>2,581,892.3</b>	<b>2,492,968.0</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>1,893,484.3</b>	<b>1,859,635.4</b>
210101	Үндсэн цалин	1,492,537.0	1,470,517.5
210102	Нэмэгдэл	110,000.0	105,727.4
210103	Унаа хоолны хөнгөлөлт	8,700.0	6,758.0
210104	Урамшуулал	123,918.5	122,138.5
210105	Гэрээт ажлын хөлс	158,328.8	154,494.0
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>257,476.4</b>	<b>244,632.3</b>
210201	Тэтгэврийн даатгал	181,893.3	171,413.4
210202	Тэтгэмжийн даатгал	18,895.5	18,373.3
210203	ҮОМШӨ-ний даатгал	15,117.4	14,954.2
210204	Ажилгүйдлийн даатгал	3,779.1	3,622.2
210205	Эрүүл мэндийн даатгал	37,791.1	36,269.1
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>140,433.7</b>	<b>115,506.6</b>
210301	Гэрэл, цахилгаан	25,666.0	18,882.1
210302	Түлш, халаалт	113,645.7	96,428.5
210303	Цэвэр, божир ус	1,122.0	196.0
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>67,499.4</b>	<b>66,361.6</b>
210401	Бичиг хэрэг	7,632.9	7,575.8
210402	Тээвэр, шатахуун	37,661.2	37,037.2
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	4,220.0	3,928.0
210404	Ном, хэвлэл	1,620.0	1,620.0
210405	Хог хаягдал зайлуулах, жортон мэргэгчдийн устгал, ариутгал	1,936.0	1,790.0
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	14,429.3	14,410.6
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>109,616.2</b>	<b>104,760.7</b>
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	39,491.7	39,072.1
210502	Хоол, хүнс	60,324.5	55,957.6
210503	Нормын хувцас, зөвлөн эдлэл	9,800.0	9,731.0
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>68,764.8</b>	<b>64,746.4</b>
210601	Багаж, техник, хэрэгсэл	36,840.5	33,959.5
210602	Тавилга	9,500.0	9,308.0
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	1,040.0	652.0
210604	Урсгал засвар	21,384.3	20,826.9
<b>2107</b>	<b>Томилголт, зочны зардал</b>	<b>10,075.0</b>	<b>5,831.2</b>
210702	Дотоод албан томилголт	10,075.0	5,831.2
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр</b>	<b>9,214.0</b>	<b>6,188.4</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний	3,540.0	1,948.0
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	648.0	648.0
210803	Даатгалын үйлчилгээ	550.0	303.5
210804	Тээврийн хэрэгслийн татвар	276.0	198.0
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	400.0	250.0
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	900.0	863.1
210807	Газрын төлбөр	300.0	157.3
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	1,000.0	231.0
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, балтгах	1,600.0	1,589.5
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>25,328.5</b>	<b>25,305.4</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	23,098.1	23,075.9
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,230.4	2,229.5
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>44,059.4</b>	<b>33,171.7</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>44,059.4</b>	<b>33,171.7</b>
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	19,869.4	18,342.7
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	24,190.0	14,829.0
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>192,102.5</b>	<b>108,357.2</b>
223001	Бусад хөрөнгө	192,102.5	108,357.2
<b>23</b>	<b>ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ</b>	<b>69,500.0</b>	<b>69,293.4</b>
230001	Эргэж төлөгдөх зээл	69,500.0	69,293.4
<b>III</b>	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>2,887,554.2</b>	<b>2,655,708.8</b>
<b>31</b>	<b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>1,920,031.3</b>	<b>1,884,725.3</b>
310003	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	1,920,031.3	1,884,725.3
<b>32</b>	<b>ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>753,393.5</b>	<b>713,124.5</b>
320001	Орон нутгийн төсвөөс	677,091.0	636,822.0
320002	Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих	76,302.5	76,302.5
<b>33</b>	<b>НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>28,329.4</b>	<b>8,251.6</b>
330002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	28,329.4	8,251.6
<b>35</b>	<b>ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС</b>	<b>185,800.0</b>	<b>49,607.4</b>
350001	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	30,000.0	46,885.1
350002	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	2,722.3
350003	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	155,800.0	-
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	180,993.4
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	132,911.8

## 2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан /мянган төгрөг/

Код	Үзүүлэлт	ТЗ цэвэр дүн
II	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>246,987.5</b>
21	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>238,987.5</b>
210	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>195,552.0</b>
2101	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>49,531.6</b>
210102	Нэмэгдэл	35,019.9
210104	Урамшуулал	14,511.7
2102	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>5,838.9</b>
210201	Тэтгэврийн даатгал	5,838.9
2104	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>4,112.4</b>
210401	Бичиг хэрэг	1,434.4
210402	Тээвэр, шатахуун	1,650.5
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	32.0
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	995.5
2105	<b>Нормативт зардал</b>	<b>118,494.2</b>
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	77,694.2
210502	Хоол, хүнс	10,640.0
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	30,160.0
2106	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>3,525.0</b>
210601	Багаж, техник, хэрэгсэл	1,620.0
210604	Урсгал засвар	1,905.0
2107	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>1,214.8</b>
210702	Дотоод албан томилолт	1,214.8
2108	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>1,855.0</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр	1,855.0
2109	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>10,980.1</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	8,300.1
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,680.0
213	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>43,435.4</b>
2132	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>40,600.0</b>
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	40,600.0
2133	<b>Олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>2,835.4</b>
213405	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас,	2,835.4
22	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>8,000.0</b>
2200	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	<b>8,000.0</b>
223001	Бусад хөрөнгө	(50,664.0)
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	58,664.0
I	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>246,988.4</b>
1311	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>246,988.4</b>
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив,	3,369.7
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс	8,000.0
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод	229,948.7
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий	5,670.0
III	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)</b>	<b>1.0</b>
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эжний үлдэгдэл	-
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	1.0

## 3. Аудитын тайлан

### 3.1. Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Баян-Уул сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Говь-Алтай аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Г.Энхдэлгэр гүйцэтгэж, хяналтыг ахлах аудитор Ж.Бүжинханд, аудитын менежер Д.Эрдэнэчимэг, дарга, тэргүүлэх аудитор Х.Түвшинбаяр нар тус тус хэрэгжүүлсэн.

Баян-Уул сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Говь-Алтай аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 3 дугаар сарын 7-ны өдрийн 1/78 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

### **3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт**

Зорилго: Сумын иргэд олон нийтийн санал санаачилгад тулгуурлан төрийн үйлчилгээг иргэн бүрт шуурхай жигд хүртээмжтэй үнэн ч шударгаар хүргэх.

Зорилт: Бодлогыг хэрэгжүүлэх үйл ажиллагааны чадавхи сайтай, төрийн үйлчилгээг иргэн бүрт хүргэгч, нутгийн захиргааны төлөвшсөн байгууллага болон хөгжих явдал юм гэж тодорхойлжээ.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт орсон байна.

Коронавируст халдварт /Ковид-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийг 2020 онд баталсан. Засгийн газрын 2021 оны “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай” 43 дугаар тогтоолд төсвийн хөрөнгийг үр ашигтай зарцуулж, төсөвт зардлыг хэмнэхэд чиглэсэн 9 арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг эрүүл мэнд, онцгой байдал, мэргэжлийн хяналт, гааль болон төрийн чиг үүргийн байгууллагаас бусад байгууллагад даалгасан байна.

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуульд шууд худалдан авч болох төсөвт өртгийн дээд хязгаарыг шинэчлэн тогтоожээ.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Төсвийн ерөнхийлөн захирагчийн дэргэдэх Санхүүгийн хяналт аудитын алба нь 2021 онд Бугат сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн үйл ажиллагаа, шилэн дансны хуулийн хэрэгжилтэд дотоод аудит хийгээгүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Баян-Уул сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 оны нэгтгэсэн санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Баян-Уул сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

### 3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл бага гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны үр дүнгийн тайлангийн нийт зардлын 2,321.4 сая төгрөгөөс 2 хувиар буюу 46.4 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 80 хувиар буюу 37.1 сая төгрөгөөр тогтоосон.

Гүйцэтгэлийн шатанд 2021 оны санхүүгийн тайлангийн нийт зардал 3,625.1 сая төгрөгөөс 2 хувиар буюу 72.5 сая төгрөгөөр тооцсон. АДБОУС 2320-н 13-д зааснаар санхүүгийн тайланд анхлан тогтоосноос бага материаллаг байдал зохистой тул гүйцэтгэлийн материаллаг байдлыг шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзлээ.

### 3.5 Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн тодруулга

Баян-Уул сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 16 хувиар буюу 1,037.9 сая төгрөгөөр өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан авлага, бараа материал, үндсэн хөрөнгө, өглөг, эздийн өмчийн данс байна.

Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл 272.6 сая төгрөг болж 25.6 сая төгрөгөөр өссөн байна. Үүнээс орон нутгийн ерөнхий орлогын дансанд 138.9 сая төгрөг, Орон нутгийн хөгжлийн сангийн дансанд 86.7 сая төгрөг, Сум хөгжүүлэх сангийн дансанд 38.7 сая төгрөг, Байгаль хамгаалах,

нөхөн сэргээх сангийн дансанд 0.8 сая төгрөг, сумын Эрүүл мэндийн төвийн дансанд 7.5 сая төгрөгийн үлдэгдэл төрийн сангийн харилцах дансанд тус тус байна.

Авлага дансны үлдэгдэл 288.0 сая төгрөг болж өссөн нь Эрүүл мэндийн төвийн Эрүүл мэндийн даатгалын сангийн нэмэлт орлогоос авах татаас санхүүжилтын 146.4 сая төгрөгийн авлага үүссэнтэй холбоотой. Тайлант оны эцэст Сум хөгжүүлэх сангийн 141.5 сая төгрөгийн, Эрүүл мэндийн төвийн Эрүүл мэндийн даатгалын сангийн нэмэлт орлогоос авах татаас санхүүжилтын 146.4 сая төгрөгийн, нийт 288.0 сая төгрөгийн авлага үүссэн байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 480.3 сая төгрөг болж 73.6 сая төгрөгөөр өссөн нь үнэ төлбөргүй хүлээн авсан бараа материал нэмэгдсэнтэй холбоотой байна. Тайлант хугацаанд төсвийн хөрөнгөөр 460.3 сая төгрөгийн, үнэ төлбөргүйгээр 287.3 сая төгрөгийн бараа материал бэлтгэж үйл ажиллагаандаа 674.0 сая төгрөгийн материалыг зарцуулжээ. Оны эцэст 515.9 сая төгрөгийн бараа материалын үлдэгдэлтэй байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 8,387.7 сая төгрөг болж 1,595.3 сая төгрөгөөр өссөн нь төсвийн хөрөнгөөр 83.3 сая төгрөгийн хөрөнгө бэлтгэж, 1,727.3 сая төгрөгийн хөрөнгийг үнэ төлбөргүйгээр хүлээн авсантай холбоотой байна.

Тайлант онд 120.2 сая төгрөгийн хөрөнгийг акталсан ба тайлант оны эцэст 8,387.7 сая төгрөгийн үндсэн хөрөнгийн үлдэгдэлтэй байна.

Өр төлбөрийн дансны үлдэгдэл 8.6 сая төгрөг болж 0.5 сая төгрөгөөр өссөн нь оны эхний 8.1 сая төгрөгийн өглөгийн барагдуулж, Эрүүл мэндийн төвийн эмийн 8.6 сая төгрөгийн өглөг шинээр үүссэнтэй холбоотой. Тайлант оны эцэст 8.6 сая төгрөгийн өглөгтэй байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 7,552.6 сая төгрөг болж 1,037.5 сая төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүнгээс шалтгаалжээ.

Орлого өмнөх оноос 17 хувиар буюу 525.0 сая төгрөгөөр өссөн нь үнэ төлбөргүй хүлээн авсан хөрөнгийн орлоготой холбоотой байна.

Өмчийн өөрчлөлтийн тайлангаар өмнөх оны үр дүн рүү хаасан бичилт хийгдээгүй ба тайлант оны хуримтлагдсан үр дүнгийн эцсийн үлдэгдэл 2,399.0 сая төгрөг болсон байна.

### **3.5.1 Орлогын данс**

Тайлант онд 188.6 сая төгрөгийн татварын орлого, 465.7 сая төгрөгийн татварын бус орлого, 2,912.5 сая төгрөгийн тусламж санхүүжилтийн орлого нийт 3,566.7 сая төгрөгийн үйл ажиллагааны орлого хүлээн зөвшөөрч бүртгэсэн байна.

### **3.5.2 Зардлын данс**

Тайлант онд 3,461.9 сая төгрөгийн үйл ажиллагааны зардал, 163.2 сая төгрөгийн үйл ажиллагааны бус зардал хүлээн зөвшөөрч бүртгэсэн.

### **3.5.3 Орон нутгийн төсвийн орлого бүрдүүлэлт**

Баян-Уул сумын ИТХ-ын 2021 оны 12 дугаар сарын “Сумын 2021 оны төсөв тодотгон батлах тухай” 24 дүгээр тогтоолд зааснаар Баян-Уул сумын төсвийн төвлөрүүлэн захирагч тайлант онд 111.4 сая төгрөгийн татварын 4.3 сая төгрөгийн татварын бус нийт 115.7 сая төгрөгийн орлого орон нутгийн төсөвт төвлөрүүлэхээр батлагдсанаас гүйцэтгэлээр 193.3 сая төгрөгийн орлогыг бүрдүүлж, төлөвлөгөөг 167 хувиар биелүүлсэн байна.

Орон нутгийн орлого тасраагүй байна.

Орлогын гүйцэтгэлийг өмнөх оны гүйцэтгэлтэй харьцуулахад Ан амьтны нөөц ашигласны төлбөр өндөр дүнгээр нэмэгдсэн байна.

### 3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### 3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 2,887.6 сая төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсөв захирагчид хүргүүлсэн төсвийг 2,887.6 сая төгрөгөөр баталжээ.

#### 3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсөв захирагчийн 9 хөтөлбөрийн хүрээнд 29 арга хэмжээг төсвөөс санхүүжүүлэхээр 2,887.6 сая төгрөгийн төсөв баталсан байна.

Гүйцэтгэлээр тусгай зориулалтын шилжүүлгээс 1,920.0 сая төгрөгийн, орон нутгийн төсвөөс 677.1 сая төгрөгийн, орон нутгийн хөгжлийн сангаас 76.3 сая төгрөгийн, эрүүл мэндийн даатгалын сангаас 8.3 сая төгрөгийн санхүүжилт авч, төсөвт байгууллагын өөрийн үйл ажиллагаанаас 49.6 сая төгрөгийн орлого орж, урсгал үйл ажиллагаанд 2,703.8 сая төгрөгийг зарцуулж 75.6 сая төгрөгийг төсөвт буцаан төвлөрүүлсэн байна. Мөнгөн хөрөнгийн 181.0 сая төгрөгийн эхний үлдэгдэл 48.1 мянган төгрөгөөр буурч 132.9 сая төгрөг болсон.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 2,703.8 сая төгрөг буюу 94 хувьтай байгаа нь цалин хөлс болон нэмэгдэл урамшлыг 33.8 сая төгрөгөөр, ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэлийг 12.8 сая төгрөгөөр, байр ашиглалттай холбоотой тогтмол зардлыг 24.9 сая төгрөгөөр, хангамж, бараа материалын зардлыг 1.1 сая төгрөгөөр, нормативт зардлыг 4.8 сая төгрөгөөр, эд хогшил, урсгал засварын зардлыг 4.0 сая төгрөгөөр, томилолт, зочны зардлыг 4.2 сая төгрөгөөр, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамжийг 3.0 сая төгрөгөөр тус тус хэмнэж зарцуулсантай холбоотой байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 2.5-д харуулав.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

#### 3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн дансаар 247.0 сая төгрөгийн орлого хүлээн авсан ба төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламжийн 3.4 сая төгрөгийн, ЗГНХ,ЗДНХ хөрөнгө, түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө 8.0 сая төгрөгийн, дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө 229.9 сая төгрөгийн, төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 5.7 сая төгрөгийн орлогыг тайлагнасан. 2.8 сая төгрөгийг үндсэн дансанд буцаан

КОД: ГАА-2022/01/-НА-СТА-ТТЗ

татан төвлөрүүлсэн байна. Нэмэлт санхүүжилтийн орлогыг цалин хөлс болон нэмэгдэл урамшил, ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл, хангамж, бараа материалын зардал, нормативт зардал, эд хогшил, урсгал засварын зардал, томилолт, зочны зардал, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж, бараа үйлчилгээний бусад зардалд зарцуулжээ.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

### **3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг**

Тодорхойлсон тодорхой бус байдал үүссэн, хэрэглэгчдэд хамааралтай санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудалгүй болно.

### **3.8 Аудитын гол асуудал**

Тодорхойлсон тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх асуудлууд байхгүй болно.

#### **3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд Шилэн дансны цахим хуудсанд оруулбал зохих 156 мэдээллээс 154 мэдээллийг хугацаандаа мэдээлсэн ба хугацаа хоцроосон мэдээлэл 2 байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн байна гэж дүгнэлээ.

#### **3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт**

##### **Төсвийн төвлөрүүлэн захирагчийн хувьд :**

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн нэгтгэсэн тайлангаар 26.5 сая төгрөгийн зөрчил илэрч 26.5 сая төгрөгийн зөрчилд зөвлөмж, 1 албан шаардлага хүргүүлсэн. Төсөвт байгууллагуудын татварын тодорхойлолт зөрүүтэй байгаад зөвлөмж хүргүүлсэн боловч зөрчил арилаагүй тул нэгж байгууллагуудад албан шаардлагаар хүргүүлсэн. Өмнөх онд хүргүүлсэн албан шаардлын тухайд шийдвэр биелсэн байна.

##### **Харьяа нэгж байгууллагын тухайд:**

Харьяа нэгж байгууллагуудад хүргүүлсэн шийдвэрүүд бүрэн биелсэн. Харин Ерөнхий боловсролын сургуулийн 183.2 сая төгрөгийн албан шаардлагыг хэрэгжүүлээгүй байна.

Хэрэгжээгүй шийдвэрийн тухайд байгууллагын удирдлагад биелэлт ирүүлэх албан бичиг хүргүүлсэн төдийгүй холбогдох албан тушаалтанд хариуцлага тооцуулсан байна. Цаашид санхүүгийн ажилтны хариуцлагыг сайжруулан зөрчлийг давтан гаргахгүй байж өмнөх аудитын шийдвэрийг хангаж ажиллах нь зүйтэй байна.

### 3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар төсөвт байгууллагуудын татварын тодорхойлолт, өмнөх аудитын шийдвэрийг үзэх нь зүйтэй.

#### 4. Аудитын илрүүлэлт

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд харьяа 6 төсвийн байгууллага, 4 тусгай сангийн нийт 10 санхүүгийн тайлан нэгтгэгдсэнээс 4 байгууллага, 1 санд дүгнэлт гаргаж, 2 байгууллага, 2 сангийн ажил гүйлгээг түүвэрт хамруулсан.

Аудитад хамрагдсан харьяа байгууллагуудын санхүүгийн тайланд “Зөрчилгүй” 2, “Хязгаарлалттай” 3 дүгнэлт өгсөн байна.

#### Дүгнэлт гарсан нэгж байгууллагын аудитын илрүүлэлт:

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн нэгтгэсэн тайланд нэгтгэгддэг аудитын дүгнэлт гарсан нэгж байгууллагуудад 1,096.9 сая төгрөгийн алдаа, зөрчил илрүүлснээс 27.2 сая төгрөгийн алдааг аудитын явцад залруулж, 20.3 сая төгрөгийн 3 зөрчилд төлбөрийн акт тогтоож, 1,049.5 сая төгрөгийн 17 зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлсэн байна. Аудитаар өгөгдсөн шийдвэрийг чанартай биелүүлж, нотлох баримтаар дэмжигдсэн хэрэгжилтийг өгөгдсөн хугацаанд ирүүлэхийг анхаарах хэрэгтэй.

#### Төсвийн төвлөрүүлэн захирагчийн нэгтгэсэн тайлангийн аудитын илрүүлэлт:

Аудитаар нийт 9.9 сая төгрөгийн алдаа зөрчил илэрч 4 албан шаардлага хүргүүлээ.

#### 4.1 Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн залруулга

Санхүүгийн нэгтгэсэн тайлан- Залруулга хийгдээгүй.  
Түүвэрт хамрагдсан байгууллага -Залруулга хийгдээгүй.

#### 4.2 Төвлөрүүлэн захирагчийн Төлбөрийн акт

Санхүүгийн нэгтгэсэн тайлан - Төлбөрийн акт тогтоогоогүй.  
Түүвэрт хамрагдсан байгууллага - Төлбөрийн акт тогтоогоогүй.

#### 4.3 Төвлөрүүлэн захирагчийн Албан шаардлага

Санхүүгийн нэгтгэсэн тайлан- Албан шаардлага хүргүүлээгүй.

#### Төсвийн төвлөрүүлэн захирагчийн нэгтгэсэн тайлангийн аудитын илрүүлэлт:

##### Баян-Уул сумын ИТХ

Батлагдсан төсвийг 10-аас доошгүй хувийн хэмнэлт гаргахаар төлөвлөж зарцуулаагүй нь Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолын 1.1-т "үндсэн үйл ажиллагаатай холбоотой, зайлшгүй шаардлагатайгаас бусад бүх төрлийн зардал, төсөл, арга хэмжээг тэвчиж, зардлыг гаргахгүй байх зэргээр батлагдсан төсөвт зардлын дүнд 10-аас доошгүй хувийн хэмнэлт гаргахаар тооцож, урсгал болон хөрөнгө оруулалтын зардлыг төлөвлөн хуваарилах" заалттай нийцэхгүй бөгөөд нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул албан шаардлага хүргүүлээ.

Татварын тодорхойлолтоор 8.7 сая төгрөгийн зөрүү тооцоо татварын цахим системд бүртгэлтэй байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4-т "Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ", 14.4.1-т "Аж ахуйн бүх ажил, гүйлгээ", 14.4.2-т "Бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, авлага", 14.4.3-т "Бүх өр төлбөр" заалттай нийцэхгүй бөгөөд нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул албан шаардлага хүргүүлээ.

### Баян-Уул сумын Соёлын төвд

Батлагдсан төсвийг 10-аас доошгүй хувийн хэмнэлт гаргахаар төлөвлөж зарцуулаагүй нь Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолын 1.1-т "үндсэн үйл ажиллагаатай холбоотой, зайлшгүй шаардлагатайгаас бусад бүх төрлийн зардал, төсөл, арга хэмжээг тэвчиж, зардлыг гаргахгүй байх зэргээр батлагдсан төсөвт зардлын дүнд 10-аас доошгүй хувийн хэмнэлт гаргахаар тооцож, урсгал болон хөрөнгө оруулалтын зардлыг төлөвлөн хуваарилах" заалттай нийцэхгүй бөгөөд нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул албан шаардлага хүргүүлээ.

Татварын тодорхойлолтоор 1.3 сая төгрөгийн зөрүү тооцоо татварын цахим системд бүртгэлтэй байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4-т "Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ", 14.4.1-т "Аж ахуйн бүх ажил, гүйлгээ", 14.4.2-т "Бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, авлага", 14.4.3-т "Бүх өр төлбөр" заалттай нийцэхгүй бөгөөд нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул албан шаардлага хүргүүлээ.

### 4.4 Төвлөрүүлэн захирагчийн Зөвлөмж

Санхүүгийн нэгтгэсэн тайлан- Зөвлөмж хүргүүлээгүй.

Түүвэрт хамрагдсан байгууллага- Зөвлөмж хүргүүлээгүй.

### 5.Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Санхүүгийн тайлангийн аудитын асуудал											
Төсвийн төвлөрүүлэн захирагч											
. .... сумын Төвлөрүүлэн захирагч											
Түүвэрт хамрагдсан байгууллага											
Соёлын төв		2	1.2					2	1.2		
ИТХ		2	8.7					2	8.7		
Дүн		4	9.9					4	9.9		
Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал											
Төсвийн төвлөрүүлэн захирагч											
Дүн											
Соёлын төв											
ИТХ											
Дүн											
Нийт дүн		4	9.9					4	9.9		